

# Яагаад селестиал хаант улсад орохын тулд бүхий л чадлаа дайчлан хичээн чармайвал зохих вэ?

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Таны нэг найз селестиал хаант улсад орохын тулд бүхий л чадлаа дайчлан хичээн чармайх хэрэггүй гэж боддог гэж төсөөл.

Селестиал хаант улсад орохын тулд сайн мэдээний дагуу амьдрахад тавигддаг аливаа шаардлагыг бүхий л чадлаа дайчлан дагахад харамсах зүйл үгүй гэдгийг найздаа ойлгоход нь туслах богино хариулт бэлд. Хариултаа бэлдэхэд тань туслах дараах эх сурвалжуудын заримыг нь ашиглаж, дараах асуултуудад хариулж болно. Үүнд:

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Л.Том Пэрри (1922–2015) ийн заасан.



Хэрэв бид мөнх амьдралын талаар тодорхой бөгөөд үнэн зураглалыг оюун санаандаа бүтээж чадвал биеэ өөрөөр авч явна гэж би итгэдэг. Бид тохинуулах, цуглаандаа явах, ариун сүмд явах, ёс зүйтэй амьдрах, залбирах эсвэл судруудыг унших зэрэг эцсээ хүртэл тэвчихэд шаардлагатай олон зүйлийг хийхээр албадуулахгүй байх болно. Бид эдгээр нь биднийг очихыг хүсдэг газартаа очиход бэлтгэх болно гэдгийг ухаарсан учраас эдгээр бүх зүйлийг болон түүнээс ч ихийг хийхээр хүсэх нь лавтай байсан. (L. Tom Perry, "The Gospel of Jesus Christ," *Ensign* эсвэл *Liahona*, May 2008, 44)

Илчлэл 7:13–17

Илчлэл 21:22–27

Мозая 2:41

Сургаал ба Гэрээ 76:51–52, 59–60; 69–70

Сургаал ба Гэрээ 130:2

Таныг ямар хариулт өгөхөө бодож үзэхэд дараах асуултуудын зарим нь бодол санаагаа удирдан чиглүүлэхэд тусалж болох юм. Үүнд:

- Селестиал хаанд улсад амьдрах талаар бодох үед юу таны сэтгэлийг хөдөлгөдөг вэ?
- Аврагчийн талаар олж мэдсэн ямар зүйл тань танд Түүнийг дагаж, селестиал хаант улсад орохыг хичээн чармайх сэдлийг төрүүлдэг вэ?
- Таны Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой холбоотой ямар ямар туршлага Тэдэнтэй дахин хамт амьдрах хүслийг тань нэмэгдүүлдэг вэ?
- Тэдний таныг гэх хайр селестиал хаант улсад орох боломжтой гэдгийг мэдрэхэд хэрхэн тусалсан бэ?